



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС, ЗӨВЛӨЛТ  
СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН  
ХООРОНД ИРГЭН ГЭР БУЛИМ, БОЛОН ЭРҮҮГИЙН  
ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА  
ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчид,

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хоорондын найрамдал, хамтын ажиллагааны болон харилцан туслалцах тухай 1966 оны нэгдүгээр сарын 15-ны өдрийн Гэрээний дагуу хоёр орны ард түмний хоорондын ах дүүгийн харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх хүсэл эрмэлзлэлийг удирдлага болгон,

эрх зүйн харилцааны салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэхийн ач холбогдлыг чухалчлан үзэж энэ Гэрээг байгуулахаар шийдвэрлэн, энэ зорилгоор өөрсдийн бүрэн эрхт төлөөлөгчөөр:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шүүх яамны сайд Оргийн Замбалдорж,

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчид Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Шүүх яамны сайд Борис Васильевич Кравцов нарыг тус тус томилсонд тэд зохих хэлбэр, журмын дагуу олгогдсон бүрэн эрхийн үнэмлэхээ солилцоод дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.



НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

I дүгээр зүйл

Эрх зүйн хамгаалалт

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр хувийн болон эд хөрөнгийн эрхийн талаар Хэлэлцэн тохирогч тухайн Талын иргэний нэгэн адил эрх зүйн хамгаалалт эдэлнэ.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шүүх, прокурор, улсын нотариатын байгууллагад /цаашид "хуулийн байгууллага" гэж нэрлэх/, түүнчлэн иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэрэг авч хэлэлцэх эрх бүхий бусад байгууллагад чөлөөтэй, саадгүй ханцах эрхтэй бөгөөд тэдгээрт санал, хүсэлт, нэхэмжлэл гаргаж болохын зэрэгцээ байцаан шийтгэх бусад ажиллагаанд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний нэгэн адил нөхцөлөөр оролцож болно.

3. Энэ зүйлийн I, 2 дахь заалт нь шүүхээр шийдвэрлэх хөдөлмөрийн маргаанд нэгэн адил хамаарна.

4. Энэ Гэрээний заалтууд Хэлэлцэн тохирогч Талуудын хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

2 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэх

1. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хуулийн байгууллага нь иргэн /хөдөлмөрийнхийг оролцуулаад/, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцааг энэ Гэрээний заалтуудын дагуу харилцан үзүүлнэ.



2. Хуулийн байгууллага энэ зүйлийн I-д заасан хэргийг авч хэлэлцэх эрх бүхий бусад байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлнэ.

### 3 дугаар зүйл

#### Харилцах журам

I. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллага эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ энэ Гэрээнд өөр журам тогтоогоогүй бол өөрийн зохих төв байгууллагаар дамжуулан харилцаж байна.

2. Энэ Гэрээнд заасан эрх бүхий хуулийн байгууллага гэж шүүх, прокурор болон улсын нотариатын байгууллагыг хэлнэ.

3. Энэ Гэрээнд заасан төв байгууллага гэж Бүгд Найрамдах Монгол Ард Улсын талаас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шүүх яам, Улсын Прокурорын газар, Улсын Дээд шүүхийг; Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын талаас Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Шүүх яам, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Прокурорын газар, харин Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Дээд шүүхийн шүүхийн үйл ажиллагааны асуудлаар Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Дээд шүүхийг тус тус хэлнэ.

4. Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Автономит Бүгд Найрамдах Улс, хязгаар, муж болон Бүгд Найрамдах Монгол Ард Улсын аймгийн хил залгаа нутаг дэвсгэрт үүссэн бөгөөд энэ Гэрээний 4 дүгээр зүйлд заасан шүүхийн шийдвэр биелүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэхээс бусад асуудлаар эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ тэдгээрийн хуулийн байгууллага өөр хоорондоо шууд харилцаж болно.



## 4 дүгээр зүйл

## Эрх зүйн туслалцааны хэмжээ

Хэлэлцэн тохирогч Талууд даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид заасан байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах замаар эрх зүйн туслалцааг нэг нь нөгөөдөө үзүүлнэ. Тухайлбал, бичиг баримт хүргүүлэх, гардуулан өгөх, зохигчид, яллагдагч, шүүгдэгч, ялтан, гэрч, шинжээч болон бусад этгээдийг байцаах, шүүхийн үзлэг, шинжилгээ хийх болон байцаан шийтгэх бусад ажиллагаа явуулах, түүнчлэн шүүхийн шийдвэр биелүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах, мэдээлэл өгөх замаар эрх зүйн туслалцаа үзүүлнэ.

## 5 дугаар зүйл

## Харилцах хэл

Хэлэлцэн тохирогч Талуудын хуулийн байгууллага эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар харилцахдаа хэрэв энэ Гэрээнд өөрөөр заагаагүй бол монгол, орос хэлээр харилцана.

## 6 дугаар зүйл

## Даалгаврын агуулга, хэлбэр

I. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварт дор дурдсан зүйлийг тусгасан байна:

а/даалгавар өгсөн байгууллагын нэр ;

б/даалгавар хүлээн авах байгууллагын нэр ;

в/эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварт заасан хэргийн нэр ;



г/зохигчид, яллагдагч, шүүгдэгч, ялтан, даалгаварт хамаарагдах бусад этгээдийн овог, нэр, тэдний иргэний харьяалал, мэргэжил, оршин суугаа буюу оршин байгаа газрын талаархи мэдээ, харин хуулийн этгээдийн хувьд нэр, оршин байгаа газар, боломжтой бол шаардлагатай бусад мэдээ баримт;

д/байцаан шийтгэх ажиллагаанд төлөөлөх хүмүүсийн овог, нэр, хаяг;

е/хүсэлтийн агуулга, эрүүгийн хэргийн хувьд бол үйлдэгдсэн гэмт хэргийн бодит байдлын тухай тодорхойлолт, хуулийн зүйл анги, мөн хэргийн улмаас хохирол учирсан бол түүний хэмжээний тухай мэдээ.

2.Бичиг баримтыг гардуулан өгөх тухай даалгаварт дээр зааснаас гадна уг бичиг баримтыг хүлээн авагчийн тодорхой хаяг, гардуулан өгөх бичиг баримтын нэрийг заавал дурдана.

3.Даалгавар болон илгээж байгаа бичиг баримт нь даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллагын албан ёсны тэмдэгтэй, албан тушаалтны гарын үсэгтэй байх ёстой.

4.Хэлэлцэн тохирогч Талууд эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ монгол, орос хэлээр үйлдсэн хэвлэмэл хуудас хэрэглэж болох бөгөөд түүний загварыг харилцан солилцоно.

#### 7 дугаар зүйл

#### Даалгавар биелүүлэх журам

I.Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгавар хүлээн авсан байгууллага түүнийг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тог-



тоомжийг баримтална. Гэхдээ өөрийн улсын хууль тогтоомжид харшлахгүй бол даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг даалгавар өгсөн байгууллагын хүсэлтээр баримталж болно.

2. Хэрэв даалгавар хүлээн авсан байгууллага уг даалгаврыг биелүүлэх эрх бүхий биш байвал түүнийг эрх бүхий байгууллагад шилжүүлэн өгч, энэ тухайгаа даалгавар өгсөн байгууллагад мэдэгдэнэ.

3. Хэрэв даалгаврыг түүнд заасан хаягаар биелүүлэх боломжгүй бол даалгавар хүлээн авсан байгууллага нь зөв хаяг тогтоох талаар шаардлагатай арга хэмжээг өөрийн хууль тогтоомжийн дагуу авна.

4. Даалгавар хүлээн авсан байгууллага нь түүнийг биелүүлсэн газар, хугацааг даалгавар өгсөн байгууллагын хүсэлтээр өөрт нь болон сонирхогч талуудад цаг тухайд нь мэдэгдэнэ.

5. Хэрэв даалгаврыг биелүүлж чадахгүйд хүрвэл бичиг баримтыг даалгавар өгсөн байгууллагад буцааж түүнийг биелүүлэхэд саад болж байгаа шалтгааныг мэдэгдэнэ.

#### 8 дугаар зүйл

#### Гэрч буюу шинжээчийг дуудах

I. Даалгавар хүлээн авсан байгууллагаас гардуулсан дуудлагын дагуу даалгавар өгсөн байгууллагад хүрэлцэн ирсэн гэрч буюу шинжээчийг аль улсын харьяат болохыг нь үл харгалзан



даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хилийг нэвтрэн орохын өмнө үйлдсэн эрх зүйн зөрчилд холбогдуулан энэ Талын нутаг дэвсгэрт хариуцлагад татаж, баривчилж буюу ял шийтгэж болохгүй. Мөн тэдгээр хүмүүсийг тэдний гаргасан гэрчийн мэдүүлэг буюу шинжээчийн дүгнэлт, эсвэл шалгаж байгаа тухайн эрүүгийн хэрэгт холбогдуулан хариуцлагад татаж, баривчилж буюу ял шийтгэж болохгүй.

2. Гэрч буюу шинжээч нь цаашид байх шаардлагагүй гэж мэдэгдсэнээс хойш даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс бололцоо байсаар атал арван таван өдрийн дотор гарч яваагүй бол энэ зүйлийн I-д заасан баталгааг алдана. Даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс гэрч буюу шинжээч өөрөөс нь үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас гарч чадаагүй саатсан хугацааг дээрх хугацаанд оруулах тоолохгүй.

3. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт дуудагдаж ирсэн гэрч буюу шинжээч хилийн чанадад байх байр, зам хоногийн болон уналгын зардал, мөн аваагүй цалингаа нөхөж авах, түүнчлэн шинжээч шинжилгээ хийсний шагналыг авах эрхтэй. Дуудагдаж байгаа иргэн ямар зардал авах эрхтэйг зарлан дуудах хуудаст заасан байх ёстой. Дуудлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын байгууллага уг иргэний шаардлагаар зардлын урьдчилгаа олгоно.

9 дүгээр зүйл

Бичиг баримтыг гардуулах

Даалгавар хүлээн авсан байгууллага нь гардуулан өгөх бичиг баримт өөрийн улсын хэлээр бичигдсэн буюу баталгаат орчуулгатай байвал түүнийг өөрийн улсад дагаж мөрдөж байгаа



журмын дагуу гардуулна. Бусад тохиолдолд хэрэв хүлээн авагч зөвшөөрвөл уг бичиг баримтыг түүнд шилжүүлэн өгч болно.

#### Ю дугаар зүйл

##### Бичиг баримтыг гардуулсны баталгаа

Бичиг баримтыг гардуулсны баталгааг даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт дагаж мөрдөж байгаа журмын дагуу гаргана. Бичиг баримт гардуулсан он, сар, өдөр, хүлээн авсан болон гардуулж өгсөн хүний гарын үсэг, байгууллагын тэмдэг, түүнчлэн гардуулсан газар, цаг хугацааг уг бичиг баримтыг гардуулсны баталгаанд бичсэн байх ёстой.

#### II дүгээр зүйл

##### Бичиг баримт хүчин төгөлдөр байх

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллагаас тогтоосон хэлбэрийн дагуу үйлдсэн буюу гэрчилсэн бичиг баримт, түүний хуулбар, эсвэл түүнээс хуулж авсан хэсгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ямар нэгэн нотолгоогүйгээр хүлээн зөвшөөрнө. Энэ нь зохих Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт дагаж мөрдөж байгаа журмын дагуу гарын үсэг нь батлагдсан иргэдийн бичиг баримтад нэгэн адил хамаарна.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт албан ёсны гэж үзсэн бичиг баримтыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт албан ёсны нотолгоотой бичиг баримт гэж үзнэ.



12 дугаар зүйл

Өөрийн иргэдэд бичиг баримт гардуулах, тэднийг байцаах

Хэлэлцэн тохирогч Талууд дипломат төлөөлөгчийн буюу консулын газраараа дамжуулан өөрийн иргэдэд бичиг баримт гардуулах буюу тэднийг байцаах эрхтэй.

13 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардал

1. Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал эрх зүйн туслалцаа үзүүлсний зардал нөхөн төлөхийг шаардахгүй. Хэлэлцэн тохирогч Талууд эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ нутаг дэвсгэртээ гарсан бүх зардлыг өөрсдөө хариуцаж байна.

2. Даалгавар хүлээн авсан байгууллага нь гарсан зардлын хэмжээг даалгавар өгсөн байгууллагадаа мэдэгдэж байна. Хэрэв даалгавар өгсөн байгууллага уг зардлыг төлөх үүрэг бүхий этгээдээс гаргуулж авсан бол тэр нь зардлыг гаргуулж авсан Хэлэлцэн тохирогч Талын орлого болно.

14 дүгээр зүйл

Иргэдийн хувийн эрх, ашиг сонирхолд хамаарах бичиг баримт илгээх

1. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат шугамаар ирүүлсэн хүсэлтийн дагуу иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн гэрчилгээ, боловсрол, ажилласан



хугацааны тухай зэрэг иргэний хувийн эрх, ашиг сонирхолд хамаарах бусад бичиг баримтыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талд илгээнэ.

2.Эдгээр бичиг баримтыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талд дипломат шугамаар, орчуулгагүй, үнэ төлбөргүй илгээнэ.

15 дугаар зүйл  
Мэдээлэл өгөх

Энэ Гэрээний 3 дугаар зүйлд заасан төв байгууллагууд хүсэлт гаргавал өөрийн оронд дагаж мөрдөж байгаа, эсвэл дагаж мөрдөж байсан хууль тогтоомжийн тухай болон түүнийг хуулийн байгууллагаас хэрэглэж байгаа асуудлаар нэг нь нөгөөдөө харилцан мэдээлж байна.

Х О Ё Р Д У Г А А Р Х Э С Э Г

ИРГЭН, ГЭР БҮЛИЙН ХЭРГИЙН ТАЛААРХИ  
ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА, ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА

16 дугаар зүйл

Шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөх

Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхийн ажиллагаанд оролцож байгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдэд гадаадын харьяат буку тухайн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт байнга оршин суудаггүй гэсэн үндэслэлээр шүүхийн зардал төлөх үүрэг оногдуулж болохгүй.



## II

### Байцаан шийтгэх ажиллагааны хөнгөлөлт

#### 17 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хэргийг хянан хэлэлцэхтэй холбогдож гарсан шүүхийн зардлаас чөлөөлөгдөнө. Түүнчлэн хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааг Хэлэлцэн тохирогч тухайн Талын иргэдийн нэгэн адил нөхцөл, хэмжээгээр авна.

2. Энэ зүйлийн I-д заасан хөнгөлөлт нь шийдвэрийг биелүүлэх ажиллагааг оролцуулаад тухайн хэргийн талаар явуулж байгаа байцаан шийтгэх бүх ажиллагаанд нэгэн адил хамаарна.

#### 18 дугаар зүйл

1. Хүсэлт гаргагчийн хувийн болон гэр бүл, эд хөрөнгийн байдлын тухай бичиг баримтыг үндэслэн энэ Гэрээний 17 дугаар зүйлд заасан хөнгөлөлтийг эдлүүлнэ. Уг бичиг баримтыг хүсэлт гаргагчийн оршин суугаа буюу оршин байгаа газрын Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага олгоно.

2. Хэрэв хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч хоёр Талын аль алины нь нутаг дэвсгэрт оршин суудаггүй буюу оршин байдаггүй бол харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газраас олгосон бичиг баримтыг үндэслэнэ.

#### 19 дүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэ Гэрээний 17 дугаар зүйлд заас-



наар хөнгөлөлт эдлэх тухай хүсэлтээ өөрийн улсын эрх бүхий байгууллагаар дамжуулан тавьж болно. Хүсэлт хүлээн авсан байгууллага нь гаргасан хүсэлтийг энэ Гэрээний 18 дугаар зүйлд дурдсан бичиг баримт болон хүсэлт гаргасан этгээдийн гардуулан өгсөн бусад бичиг баримтын хамт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагад илгээнэ.

2. Энэ Гэрээний 17 дугаар зүйлд заасан хөнгөлөлт эдлэх тухай хүсэлт хамтад нь хэрэг үүсгэх тухай өргөдөл болон төлөөлөгч томилох, түүнчлэн цаашид гарч болох бусад хүсэлтийг хүргүүлж болно.

3. Хөнгөлөлт эдлэх тухай хүсэлтийг шийдвэрлэх байгууллага нь бичиг баримт олгосон байгууллагаас нэмэгдэл мэдээ баримт, тайлбар шаардаж болно.

20 дугаар зүйл

Хэргийн байцаан шийтгэх ажиллагааг зогсоох

Хэлэлцэн тохирогч хоёр Талын энэ Гэрээнд заасан эрх бүхий шүүх, түүнчлэн Гэрээнд заагаагүй тохиолдолд Хэлэлцэн тохирогч зохих Талын хууль тогтоомжид заасан эрх бүхий шүүх эрх зүйн нэгэн маргааны талаар нэгэн зохигчдын хооронд байцаан шийтгэх ажиллагаа үүсгэсэн бол хэргийг сүүлд нь үүсгэсэн шүүх байцаан шийтгэх ажиллагаагаа зогсоож, энэ тухай зохигчлод мэдэгдэнэ.



ХУВИЙН ЭРХИЙН БАЙДАЛ БОЛОН ГЭР  
БҮЛИЙН ЭРХ

21 дүгээр зүйл

Эрхийн чадвар болон эрх олох,  
үүрэг бий болгох чадвар

1. Эрх олох, үүрэг бий болгох чадварыг уг хүн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

2. Ахуй амьдралын жижиг хэлцэл хийхтэй холбогдсон эрх олох, үүрэг бий болгох чадварыг нутаг дэвсгэр дээр нь уг хэлцэл хийж байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

3. Хуулийн этгээдийн эрхийн чадвар болон эрх олох, үүрэг бий болгох чадварыг түүнийг байгуулсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

22 дугаар зүйл

Сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, нас барсан үйл баримтыг тогтоох

1. Иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтоох тухай хэргийг сүүлчийн мэдээгээр уг иргэн амьд ахуй цагтаа харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий хуулийн байгууллага шийдвэрлэнэ.

2. Өөрийн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч энэ Талын хууль тогтоомжид эрх, ашиг сонирхол нь үндэслэсэн сонирхогч этгээдийн хүсэлтээр Хэлэлцэн тохи-



рогч нэг Талын хуулийн байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцож, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтоож болно.

3.Энэ зүйлийн 1,2-т заасан тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талуудын байгууллага нь өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

### 23 дугаар зүйл

#### Гэрлэх

1.Гэрлэгсдийн хэн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэн байвал тэдний гэрлэх нөхцөлийг гэрлэгч тус бүр харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно. Үүнээс гадна гэрлэхэд харшлах зүйлийн хувьд нутаг дэвсгэрт нь гэрлэж байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн шаардлагыг сахих ёстой.

2.Гэрлэх хэлбэрийг нутаг дэвсгэрт нь гэрлэж байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

### 24 дүгээр зүйл

#### Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцаа

1.Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааг тэдний байнга хамт оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.

2.Эхнэр буюу нөхрийн хэн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суудаг бөгөөд хоёулаа нэг улсын харьяат бол тэдний хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааг харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.



3. Эхнэр буюу нөхрийн хэн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын харьяат, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын харьяат бөгөөд нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт; нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суудаг бол тэдний хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааг тэд хамгийн сүүлд хамт оршин сууж байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.

4. Хэрэв энэ зүйлийн 3-т заасан гэрлэгсэд хамт оршин сууж байгаагүй бол шүүхэд нь нэхэмжлэл гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

5. Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааны асуудлыг энэ зүйлийн 1, 2, 3-т заасны дагуу хууль тогтоомжийг нь баримтлах Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Харин энэ зүйлийн 4-т заасан тохиолдолд Хэлэлцэн тохирогч хоёр Талын шүүх эрх бүхий байна.

#### 25 дугаар зүйл

##### Гэрлэснийг цуцлах

1. Гэрлэснийг цуцлахдаа гэрлэлт цуцлуулах тухай өргөдөл гаргах үед гэрлэгсэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

2. Хэрэв эхнэр буюу нөхрийн хэн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын харьяат, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын харьяат бол байгууллагад нь өргөдөл гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

3. Энэ зүйлийн 1-д заасан тохиолдолд өргөдөл гаргах үед гэрлэгсэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Хэрэв гэрлэгсэд өргөдөл гаргах үедээ Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин сууж байсан бол Хэлэлцэн тохирогч энэ Талын байгууллага эрх бүхий байна.



4.Энэ зүйлийн 2-т заасан тохиолдолд гэрлэгсэд хоёулаа нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрх бүхий байна. Хэрэв гэрлэгсдийн хэн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суудаг бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын байгууллага эрх бүхий байна.

#### 26 дугаар зүйл

##### Гэрлэснийг хүчингүйд тооцох

1.Гэрлэснийг хүчингүйд тооцохдоо хууль тогтоомжийнх нь дагуу гэрлэсэн Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

2.Гэрлэснийг хүчингүйд тооцох эрх бүхий байгууллагыг энэ Гэрээний 25 дугаар зүйлийн 3,4-т зааснаар тодорхойлно.

#### 27 дугаар зүйл

##### Эцэг эх,хүүхдийн эрхийн харилцаа

1.Хүүхдийн эцэг тогтоох болон эцгийн асуудлаар маргаантай хэргийн талаар хүүхэд төрөөд харьяат нь болсон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

2.Эцэг эх, хүүхдийн эрхийн харилцааг тэд нутаг дэвсгэрт нь хамт оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

3.Хэрэв эцэг эх буюу тэдний аль нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт, харин хүүхэд нь нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суудаг бол тэдний хоорондын эрхийн



харилцааг хүүхэд нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно. Хэрэв хүүхэд Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт оршин суудаг бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэн байгаа тохиолдолд хүүхдэд аль илүү тохиромжтой байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

4. Насанд хүрсэн хүүхдээс эцэг эхэд нь тэтгэвэр гаргуулах тухай хэргийг шийдвэрлэхдээ тэтгэвэр авахаар хүсэлт гаргасан иргэн нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

5. Энэ зүйлийн I-д заасан эрхийн харилцааны асуудлыг хүүхэд харьяат нь байгаа буюу хүүхэд нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Энэ зүйлийн 2,3,4-т заасан тохиолдолд нэхэмжлэгч нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрх бүхий байна.

#### 28 дугаар зүйл

#### Хүүхэд үрчлэх

1. Хүүхэд үрчлэн авахад үрчлэн авагч иргэн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

2. Хэрэв үрчлэгдэж байгаа хүүхэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид зааснаар үрчлэгдэгчийн буюу түүний хууль ёсны төлөөлөгчийн, мөн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авах ёстой бол уг зөвшөөрлийг заавал авна.

3. Хүүхэд үрчлэн авч байгаа эхнэр, нөхөр хоёрын хэн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэн бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль тогтоомжийг баримтална.

4. Хүүхэд үрчлэхтэй холбогдсон асуудлыг үрчлэн авагч иргэн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Энэ зүйлийн 3-т заасан тохиолдолд эхнэр, нөхөр нутаг дэвсгэрт нь хамт оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрх бүхий байна.

5. Энэ зүйлийн 1,2,3,4 дэх заалт үрчлэлтийг хүчингүй болгоход нэгэн адил хамаарна.

Асран хамгаалах, харгалзан дэмжих

29 дүгээр зүйл

1. Хэрэв энэ Гэрээнд өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохирогч Талуудын иргэдэд асран хамгаалах, харгалзан дэмжих шаардлагатай иргэн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтооно.

2. Асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоох, тэдгээрийг хүчингүй болгох нөхцөлийг асран хамгаалах, харгалзан дэмжих шаардлагатай иргэн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

3. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон асруулагчийн хоорондын эрхийн харилцааг эрх бүхий байгууллага нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилсон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

4. Асран хамгаалах, харгалзан дэмжих үүргийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр томилогдсон иргэн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.

5. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэний асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг томилж болно. Гэхдээ уг иргэн асран хамгаалах, харгалзан дэмжих



ажлыг хэрэгжүүлэх Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр дээр оршин суугаа нөхцөлд үүнийг хэрэглэнэ.

### 30 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа бузу оршин байгаа, эсвэл эд хөрөнгө нь тэнд байгаа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэнд асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилох шаардлага гарвал тухайн Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага энэ Гэрээний 29 дүгээр зүйлийн I-д заасан эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

2. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын байгууллага нь хойшлуулшгүй тохиолдолд еерийн улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч болох бөгөөд энэ тухайгаа энэ Гэрээний 29 дүгээр зүйлийн I-д заасан эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Ийнхүү авсан арга хэмжээ нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагаас өөр шийдвэр гаргах хүртэл хүчин төгөлдөр байна.

### 31 дүгээр зүйл

1. Асран хамгаалах, харгалзан дэмжих шаардлагатай иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа бузу оршин байгаа тохиолдолд уг иргэн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага тухайн иргэнд асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилох, эсвэл түр зуурын арга хэмжээ авах тухай хүсэлтийг нөгөө Талын эрх бүхий байгууллагад гаргаж болно. Хүсэлтийг хүлээн авсан байгууллага нь асран хамгаалах, харгалзан дэмжих болон түр зуурын арга хэмжээ авсан тухайгаа хүсэлт тавьсан байгууллагад мэдэгдэнэ.

2. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэнд асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоосон боловч тэр нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суухаар шилжсэн бол



асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоосон байгууллага нь нөгөө Талын байгууллагад асран хамгаалах, харгалзан дэмжих ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх тухай хүсэлт тавьж болно. Асран хамгаалах, харгалзан дэмжихийг шилжүүлсэн нь даалгавар хүлээн авсан байгууллага асран хамгаалах, харгалзан дэмжих явдлыг өөртөө хүлээн авч, энэ тухайгаа даалгавар өгсөн байгууллагад мэдэгдсэн үеэс хүчин төгөлдөр болно.

3. Асран хамгаалах, харгалзан дэмжих ажлыг хүлээн авсан байгууллага нь түүнийг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх боловч асруулагчийн хувийн эрхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргах эрхгүй.

### 32 дугаар зүйл

#### Хэлцлийн хэлбэр

1. Хэлцлийн хэлбэрийг уг хэлцлийн хувьд баримтлах Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлох боловч нутаг дэвсгэр дээр нь байгуулж байгаа Талын хууль тогтоомжийг баримталж болно.

2. Үл хөдлөх эд хөрөнгийн хэлцлийн хэлбэрийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

### 33 дугаар зүйл

#### Гэм хорыг арилгах

1. Гэм хор учруулснаас үүссэн үүргийн талаар хүлээх хариуцлагыг гэм хорыг арилгах тухай шаардлага тавих үндэслэл болсон үйл явдал буюу өөр нөхцөл байдал нутаг дэвсгэрт нь бий болсон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.



2. Гэм хор учруулсан этгээд болон хохирогч нь Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн бол учирсан гэм хорыг арилгахдаа Хэлэлцэн тохирогч энэ Талын хууль тогтоомжийг баримтална.

3. Энэ зүйлийн 1, 2-т заасан асуудлаар шийдвэр гаргахад хууль тогтоомжийг нь баримтлах Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрх бүхий байна.

ӨВ ЗАЛГАМЛАХ

34 дүгээр зүйл

Тэгш эрхийн зарчим

Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгийн болон мөн тэрхүү нутаг дэвсгэрт хэрэгдсэн байх ёстой эрхийн гэрээслэл хийх, түүнийг хүчингүй болгох, түүнчлэн эд хөрөнгө буюу эрхийг өвлөх чадварын хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнтэй тэгш эрхтэй байна. Тэдэнд эд хөрөнгө болон эрхийг өөрийн иргэдийн хувьд тогтоогдсон нөхцөлийн дагуу шилжүүлнэ.

35 дугаар зүйл

Өв залгамшлах эрх

1. Хөдлөх эд хөрөнгө өвлөх эрхийг өвлүүлэгч сүүлчийн удаа нутаг дэвсгэр дээр нь оршин сууж байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.

2. Үл хөдлөх эд хөрөнгө өвлөх эрхийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.

3. Ямар эд хөрөнгийг хөдлөх буюу үл хөдлөх гэж үзэх тухай асуудлыг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор шийдвэрлэнэ.



## 36 дугаар зүйл

Өв залгамжлал улсад шилжих

Өвлөгдөх эд хөрөнгө Хэлэлцэн тохирогч Талуудын хууль тогтоомжийн дагуу улсад шилжвэл хөдлөх эд хөрөнгө өвлүүлэгч нас барах үед харьяат байсан Хэлэлцэн тохирогч Талын орлого болно. Харин үл хөдлөх эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын орлого болно.

## 37 дугаар зүйл

Гэрээслэл

1. Гэрээслэл хийх буюу хүчингүй болгох чадвар, түүнчлэн санаа зоригоо дутуу илэрхийлснээс үүссэн эрх зүйн үр дагаврыг гэрээслэгч гэрээслэл хийх буюу хүчингүй болгох үед харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

2. Гэрээслэл хийх, түүнийг хүчингүй болгох хэлбэрийг гэрээслэгч гэрээслэл хийх, хүчингүй болгох үед харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно. Гэвч нутаг дэвсгэрт нь гэрээслэл хийсэн буюу хүчингүй болгосон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримталж болно.

## 38 дугаар зүйл

Нас барсан тухай мэдэгдэх

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэн нас барвал энэ тухай зохиох байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт нэн даруй мэдэгдэж, өв залгамжлагчийн тухай тодорхой байгаа бүх зүйл, түүний оршин суугаа буюу оршин байгаа газар, өвлөгдөх зүйлийн хэмжээ, үнэ, түүнч-



лэн гэрээслэл байгаа эсэх талаар мэдээлнэ. Хэлэлцэн тохирогч нэг Талын зохих байгууллага нь Хэлэлцэн тохирогч хоёр Талын нутаг дэвсгэрийн гадна нас барсан Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэн эд хөрөнгөө тэр улсын нутаг дэвсгэрт үлдээсэн тухай мэдээ авсан тохиолдолд энэ журмыг нэгэн адил хэрэглэнэ.

2. Хэрэв өөрийн иргэн нас барсан тухай дипломат төлөөлөгчийн буюу консулын газар түрүүлж мэдсэн бол өв залгамжлалыг хамгаалах арга хэмжээ авах эрх бүхий хуулийн байгууллагад энэ тухай мэдэгдэнэ.

### 39 дүгээр зүйл

Өв залгамжлалыг хамгаалах арга хэмжээ болон өв залгамжлах ажиллагаань талаар дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын эдлэх эрх хэмжээ

1. Хэлэлцэн тохирогч Талуудын байгууллага нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнээс тэдгээрийн нутаг дэвсгэрт үлдээсэн өвлөгдөх хөрөнгийн хамгаалалтыг хангах буюу эрхлэн гүйцэтгэх шаардлагатай арга хэмжээг хууль тогтоомжийнхоо дагуу авна.

2. Энэ зүйлийн I-д заасан арга хэмжээний тухай түүнийг хэрэгжүүлэхэд оролцож болох Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт нэн даруй мэдэгдэнэ. Энэ зүйлийн I-д заасны дагуу авсан арга хэмжээг дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын хүсэлтээр хойшлуулж буюу өөрчилж болно.

Хэрэв өөрийн улсын иргэн байхгүй байгаа бөгөөд өв залгамжлалын асуудлыг итгэмжлэгдсэн өөр хүнд хариуцуулаагүй бол түүний өв залгамжлалын бүх асуудлаар дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын ажилтан хуулийн болон бусад байгууллагад төлөөлөх эрхтэй. Энэ тохиолдолд тусгай итгэмжлэл шаардахгүй.



3. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн байнга оршин суудаггүй буюу оршин байдаггүй Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчин явах үедээ нас барсан бол түүний биедээ авч явсан эд зүйлийг ямар нэгэн ажиллагаа хийлгүйгээр уг иргэн харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт шилжүүлнэ.

#### 40 дүгээр зүйл

##### Гэрээслэлийг шилжүүлэн өгөх

Хэрэв гэрээслэл Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд өв залгамжлах ажиллагааг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хуулийн байгууллага эрхлэн гүйцэтгэх эрх бүхий байвал гэрээслэлийн баталгаатай хуулбарыг, харин хүсвэл жинхэнэ эхийг уг байгууллагад шилжүүлэн өгнө.

#### 41 дүгээр зүйл

##### Өв залгамжлалын хэргийг шийдвэрлэх эрх бүхий байгууллага

1. Хөдлөх эд хөрөнгийг өв залгамжлах тухай хэргийг өвлүүлэгч сүүлчийн удаа нутаг дэвсгэрт нь байнга оршин сууж байсан Хэлэлцэн тохирогч Талын хуулийн байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна.

2. Үл хөдлөх эд хөрөнгийг өв залгамжлах тухай хэргийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хуулийн байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна.

3. Өв залгамжлах хэргээс үүссэн маргааныг шийдвэрлэхэд энэ зүйлийн 1, 2-т заасныг баримтална.

#### 42 дугаар зүйл

##### Өв хөрөнгийг шилжүүлэх

Өв залгамжлалтай холбогдсон ажиллагаа дууссаны дараа хөд-



лөх эд хөрөнгө буюу түүнийг худалдан борлуулсны үнийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа буюу оршиж байгаа Хэлэлцэн тохирогч энэ Талын иргэн өв залгамжлагч нь харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт дор дурдсан нөхцөлд шилжүүлнэ:

а/өвлөгдөх эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа улсын хууль тогтоомжид зааснаар эрх бүхий байгууллага өвлүүлэгчээс авлагатай хүмүүсийг өргөдлийг нь гаргуулахаар дуудсан;

б/өв залгамжлалтай холбогдсон хураамжийг төлсөн, өргөдөлд дурдсан шаардлагыг хангасан буюу биелүүлсэн;

в/эд зүйлийг гаргахыг, эсвэл түүнийг худалдан борлуулсны үнийг гуйвуулахыг эрх бүхий байгууллага зөвшөөрсөн.

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ,  
БИЕЛҮҮЛЭХ

43 дугаар зүйл

Эд хөрөнгийн шинжтэй хэргийн талаархи  
шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх,  
биелүүлэх

Энэ Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гаргасан буюу хуулийн хүчин төгөлдөр болсон, түүнчлэн Иргэний ба эрүүгийн хэрэг, мөн гэр бүл, гэрлэхтэй холбогдсон хэргийн талаар хуулийн туслалцаа харилцан үзүүлэх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хоорондын 1958 оны наймдугаар сарын 25-ны өдрийн Гэрээний дагуу биелүүлэх ёстой бөгөөд энэ Гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө гарсан дор дурдсан шийдвэрийг Хэлэлцэн тохирогч Талууд уг Гэрээнд заасан нөхцөлөөр хүлээн зөвшөөрч, биелүүлнэ:



- а/иргэний /хөдөлмөрийнхийг оролцуулаад/ болон гэр бүлийн эд хөрөнгийн шинжтэй хэргийн талаархи шүүхийн шийдвэр;
- б/таслан шийдвэрлэх тогтоолын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбогдсон хэсэг.

## 44 дүгээр зүйл

Эд хөрөнгийн бус шинжтэй хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх

I.Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэний /хөдөлмөрийнхийг оролцуулаад/ болон гэр бүлийн эд хөрөнгийн бус шинжтэй хэргийн талаархи хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр, түүнчлэн ийм хэргийн талаар хуулийн бусад байгууллага, иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх болон асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэв энэ Гэрээний 48 дугаар зүйлд зааснаар хүлээн зөвшөөрөхөөс татгалзаагүй бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байцаан шийтгэх ажиллагаа явуулахгүйгээр хүлээн зөвшөөрнө. Эдгээр шийдвэрийг энэ Гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө гарсан тохиолдолд ч нэгэн адил хүлээн зөвшөөрнө.

## 45 дугаар зүйл

Шийдвэр биелүүлэхийг зөвшөөрөх тухай хүсэлт

I.Шийдвэр биелүүлэхийг зөвшөөрөх тухай хүсэлтийг уг хэргийн талаар анхан шатны журмаар шийдвэр гаргасан хуулийн байгууллагад тавина. Уг хуулийн байгууллага хүсэлтийг энэ Гэрээний 47 дугаар зүйлд заасны дагуу шийдвэр гаргах эрх бүхий шүүхэд тогтоосон журмаар хүргүүлнэ. Хэрэв шийдвэр биелүүлэ-



хийг зөвшөөрөх тухай хүсэлт тавьсан этгээд уг шийдвэрийг биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт оршин суудаг буюу оршин байдаг бол хүсэлтийг Хэлэлцэн тохирогч энэ Талын эрх бүхий шүүхэд шууд гаргаж болно.

2. Хүсэлтэд дурдвал зохих зүйлийг нутаг дэвсгэрт шийдвэрийг нь биелүүлэх Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

#### 46 дугаар зүйл

##### Хүсэлтэд хавсаргах бичиг баримт

Шийдвэр биелүүлэхийг зөвшөөрөх тухай хүсэлтэд дор дурдсан зүйлийг хавсаргана:

а/шүүхийн шийдвэр буюу түүний баталгаатай хуулбар, шийдвэрт өөрт нь шууд заагаагүй бол уг шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бөгөөд түүнийг биелүүлбэл зохих тухай албан ёсны бичиг баримт ;

б/байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй хариуцагч буюу түүний бүрэн эрхт төлөөлөгчид шүүхийн зарлан дуудах хуудсыг цаг тухайд нь зохих ёсоор гардуулсан тухай магадлагаа ;

в/энэ зүйлд заасан бичиг баримтын баталгаатай орчуулга болон хүсэлтийн орчуулга.

#### 47 дугаар зүйл

##### Шийдвэр биелүүлэхийг зөвшөөрөх

1. Шийдвэр биелүүлэхийг зөвшөөрөх тухай хүсэлтийг шийдвэр нутаг дэвсгэрт нь биелэгдэх Хэлэлцэн тохирогч Талын шүүх авч хэлэлцэнэ.

2. Шийдвэр биелүүлэхийг зөвшөөрөх тухай хүсэлтийг авч хэлэлцэж байгаа шүүх энэ Гэрээнд заасан нөхцөл бүрдсэнийг тог-

тооно. Нөхцөл бүрдсэн тохиолдолд шүүх шийдвэр биелүүлэхийг зөвшөөрнө.

3. Хэрэв шийдвэр биелүүлэх тухай асуудлыг хэлэлцэхэд шүүхэд эргэлзээ төрвөл шийдвэр биелүүлэх тухай хүсэлт тавьсан этгээдээс тайлбар өгөхийг хүсэх, түүнчлэн хүсэлтийн агуулгын талаар хариуцагчийг байцаах болон шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргасан хуулийн байгууллагаас тайлбар гаргах өгөхийг шаардаж болно.

#### 48 дугаар зүйл

Шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс  
болон биелүүлэхээс татгалзах

Шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс болон биелүүлэхээс дор дурдсан тохиолдолд татгалзаж болно:

а/биелүүлбэл зохих шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болоогүй;

б/шүүхийн зарлан дуудах хуудсыг хариуцагч буруу түүний бүрэн эрхт төлөөлөгчид цаг тухайд нь зохих ёсоор гардуулаагүйн улмаас хариуцагч байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй;

в/нутаг дэвсгэрт нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын байгууллагаас тухайн зохигчдын хооронд нэгэн асуудлаар болон нэгэн үндэслэлээр хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр урьд гаргасан буруу Хэлэлцэн тохирогч энэ Талын байгууллага уг хэргийн талаар байцаан шийтгэх ажиллагааг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талаас өмнө явуулж эхэлсэн бол;

г/энэ Гэрээнд заагаагүй боловч тухайн хэрэг нь энэ Гэрээний болон нутаг дэвсгэрт нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу Хэлэлцэн тохирогч энэ Талын байгууллагын онцгой эрх мэдэлд хамаарч байгаа бол;



д/шийдвэр биелүүлэх тухай хүсэлт гаргах гурван жилийн хугацаа өнгөрсөн бол.

49 дүгээр зүйл

Шийдвэрийг биелүүлэх

1.Шийдвэрийг биелүүлэх журмыг нутаг дэвсгэрт нь шийдвэр биелүүлэх Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

2.Хуулийн байгууллагаас нь шийдвэр гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид тохирч байвал хариуцагч шийдвэр биелүүлэхээс татгалзаж болно.

3.Шийдвэрийг биелүүлэхтэй холбогдсон шүүхийн зардлын хувьд нутаг дэвсгэрт нь шийдвэр биелэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

Шүүхийн зардлын тухай шийдвэрийг биелүүлэх

50 дугаар зүйл

1.Хэрэв энэ Гэрээний 16 дугаар зүйлийн дагуу шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдсөн иргэнд Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт шүүхийн зардал төлөх үүрэг оногдуулсан бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа зохих шүүх тухайн зардлыг үнэ төлбөргүйгээр уг хүнээс гаргуулах асуудлыг хүсэлтийн дагуу шийдвэрлэнэ.

2.Шүүхийн зардлаас гадна энэ Гэрээний 51 дүгээр зүйлд дурдсан бичиг баримтыг орчуулсны буюу гэрчилсний зардлыг мөн гаргуулна.

51 дүгээр зүйл

1.Шүүхийн зардал гаргуулах шийдвэр биелүүлэхийг зөвшөөрөх тухай хүсэлтэд уг зардлын талаархи шийдвэрийн баталгаатай хуул-



бар, шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бөгөөд түүнийг биелүүлбэл зохих тухай магадлагааг хавсаргана.

2. Дурдсан бичиг баримтыг нутаг дэвсгэрт нь шийдвэрийг биелүүлэх Хэлэлцэн тохирогч Талын хэлээр орчуулсан байна.

3. Шүүхийн зардал гаргуулах шийдвэр биелүүлэхийг зөвшөөрч байгаа шүүх зөвхөн дор дурдсан зүйлийг шалгах үзнэ:

а/ шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон эсэх, түүнийг биелүүлэх ёстой эсэх;

б/ энэ зүйлийн I-д дурдсан бичиг баримтын баталгаатай орчуулга байгаа эсэх.

4. Биелүүлэхийг зөвшөөрсөн тухай шүүхийн шийдвэрийг шүүхээс нь уг шийдвэрийг гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу давж заалдаж болно.

#### 52 дугаар зүйл

Шүүхийн зардлын талаархи шийдвэрийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт биелүүлэхийг зөвшөөрөх тухай хүсэлтийг Хэлэлцэн тохирогч энэ Талын шийдвэр биелүүлэхийг зөвшөөрөх эрх бүхий шүүхэд буюу зардлын талаархи шийдвэр гаргасан шүүхэд тавина. Сүүлчийн тохиолдолд шүүх уг хүсэлтийг энэ Гэрээний 5I дүгээр зүйлд дурдсан бичиг баримтын хамт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий шүүхэд тогтоосон журмын дагуу хургуулна.

#### 53 дугаар зүйл

1. Шүүх нь зохигчдын саналыг авахгүйгээр шүүхийн зардлын тухай шийдвэрийг биелүүлэхийг зөвшөөрнө.

2. Хүсэлт гаргасан этгээд шийдвэр биелүүлэхтэй холбогдсон зардлыг урьдчилан төлөөгүй гэсэн үндэслэлээр шүүхийн зардлын тухай шийдвэрийг биелүүлэхээс татгалзаж болохгүй.



## 54 дүгээр зүйл

Эд зүйл гаргах болон мөнгө гуйвуулах

Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрээс Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэ Гэрээний дагуу эд зүйл гаргах болон мөнгө гуйвуулахад нутаг дэвсгэрээс нь эд зүйл гаргах буюу мөнгө гуйвуулах улсын хууль тогтоомжийг баримтална.

## 55 дугаар зүйл

Эвлэрэх хэлэлцээ

Энэ Гэрээний 43-54 дүгээр зүйлийн заалтууд шүүхэд ирж эвлэрэх хэлэлцээнд нэгэн адил хамаарна.

Г У Р А В Д У Г А А Р Х Э С Э Г  
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААРХИ ЭРХ ЗҮЙН  
ТУСЛАЛЦАА

ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ

## 56 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх үүрэг

1. Хэлэлцэн тохирогч Талууд энэ Гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу өөрийн нутаг дэвсгэрт байгаа этгээдийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахын тулд буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхийн тулд бие биенийхээ шаардлагын дагуу шилжүүлэн өгөх үүрэг хүлээнэ.

2. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль тогтоомжид зааснаар гэмт хэрэг гэж үзэх хэрэг үйлдсэн бөгөөд тэр хэрэгт нь нэг жилээс дээш хугацаагаар хорих буюу еөр хүнд ял оногдуулах зөвхөн тийм хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар шилжүүлэн өгч болно.



Зургаан сараас дээш хугацаагаар хорих буюу өөр хүнд ял шийтгэл оногдуулах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг ял шийтгэсэн бөгөөд хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр шилжүүлэн өгч болно.

#### 57 дугаар зүйл

##### Шилжүүлэн өгөхөөс татгалзах

1. Шилжүүлэн өгөх шаардлагыг дор дурдсан тохиолдолд татгалзана:

а/шилжүүлэн өгөхийг шаардсан этгээд нь шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын иргэн байгаа ;

б/шаардлага хүлээж авах үед шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид зааснаар хөөн хэлэлцэх хугацаа дууссан, өршөөл үзүүлсэн буюу хууль зүйн бусад үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэж, эсвэл таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлж болохгүй болсон ;

в/шилжүүлэн өгөхийг шаардсан этгээдийн хувьд шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт тухайн гэмт хэргийн талаар хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоол гарсан буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон.

2. Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт үйлдсэн хэрэгтэй холбогдуулан шилжүүлэн өгөхийг шаардаж байгаа бол шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно.

3. Шилжүүлэн өгөхөөс татгалзсан тохиолдолд татгалзаж байгаагаа үндэслэлээ даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ.

#### 58 дугаар зүйл

##### Шилжүүлэн өгөх тухай шаардлага

1. Шилжүүлэн өгөх тухай шаардлагад дор дурдсан зүйлийг тусгасан байна:



- а/шаардлага тавьсан байгууллагын нэр ;
- б/шаардлага тавьсан Хэлэлцэн тохирогч Талын хуулийн тухайн хэргийг гэмт хэрэг гэж тодорхойлсон заалт ;
- в/шилжүүлэн өгөх этгээдийн овог, нэр, иргэний харьяалал, оршин суугаа буюу оршин байгаа хаягийн тухай мэдээ, түүнчлэн бололцоотой бол түүний гадаад төрх байдлын тодорхойлолт, хувийн байдлын тухай бусад мэдээ ;
- г/хэрэв гэмт хэргийн улмаас хохирол учирсан бол хохирлын хэмжээний тухай мэдээ.

2. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар шилжүүлэн өгөх шаардлагад баривчлах тухай тогтоолын баталгаатай хуулбарыг, харин таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхээр шилжүүлэн өгөх тухай шаардлагад түүний хуулийн хүчин төгөлдөр болсон нотолгоо бүхий баталгаатай хуулбар болон уг этгээдийг ял шийтгэх үндэслэл болсон эрүүгийн хуулийн заалтыг хавсаргана. Хэрэв ялтан ялынхаа зарим хэсгийг эдэлсэн бол энэ тухай нэгэн адил мэдэгдэнэ.

59 дүгээр зүйл

Шилжүүлэн өгөхөөр цагдан хорих

Шилжүүлэн өгөх тухай шаардлага хүлээн авмагц даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгч болохгүй гэж энэ Гэрээнд зааснаас бусад тохиолдолд шилжүүлэн өгвөл зохих этгээдийг цагдан хорих арга хэмжээг нэн даруй авна.

60 дугаар зүйл

Нэмэлт мэдээ

I. Шилжүүлэн өгөх тухай шаардлагад хэрэгцээтэй бүх мэдээ баримт тусгагдаагүй бол даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нэмэгдэл мэдээ шаардаж болох бөгөөд үүний тулд 2 сар хүртэл хугацаа тогтоож өгнө. Хүндэтгэн үзэх шалтгаантай

бол энэ хугацааг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хүсэлтээр сунгаж болох боловч 2 сараас хэтрэхгүй.

2. Хэрэв тогтоосон буруу сунгасан хугацаанд энэ зүйлийн I-д заасан нэмэгдэл мэдээг авч чадаагүй бол даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага шилжүүлэн өгөх ажиллагааг зогсоож цагдан хоригдсон этгээдийг суллаж болно.

### 6I дүгээр зүйл

Шилжүүлэн өгөх тухай шаардлагыг  
хүлээн авахын өмнө цагдан хорих

1. Шилжүүлэн өгвөл зохих этгээдийг цагдан хорих тухай тогтоол буруу хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолыг иш үндэс болгож даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талаас тавьсан хүсэлтээр шилжүүлэн өгөх тухай шаардлага ирэхээс өмнө түүнийг цагдан хорьж болно. Гэхдээ хүсэлт тавьсан байгууллага шилжүүлэн өгөх тухай шаардлагыг явуулсан гэдгээ давхар мэдэгдэнэ. Ийм хүсэлтийг шуудан, цахилгаан, телефон буруу бусад аргаар дамжуулж болно.

2. Хэрэв тухайн этгээд шилжүүлэн өгвөл зохих гэмт хэргийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт үйлдсэн гэдэг лавтай үндэслэл байвал Хэлэлцэн тохирогч аль ч Талын эрх бүхий байгууллага нь еерийн нутаг дэвсгэрт байгаа этгээдийг энэ зүйлийн I-д заасан шаардлагыг хүлээлгүйгээр баривчилж болно.

3. Энэ зүйлийн I, 2-т зааснаар цагдан хорьсон тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талд нэн даруй мэдэгдэж байна.

### 62 дугаар зүйл

Түр цагдан хоригдсон этгээдийг суллах

Энэ Гэрээний 6I дүгээр зүйлд зааснаар цагдан хорьсон этгээдийг энэ тухай мэдээ явуулсан өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд

цаанд Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас шилжүүлэн өгөх тухай шаардлага ирээгүй бол цагдан хоригдсон этгээдийг суллах ёстой. Уг этгээдийг цагдан хорихоос сулласан тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талд мэдэгдэнэ.

#### 63 дугаар зүйл

##### Шилжүүлэн өгөхийг хойшлуулах

Шилжүүлэн өгвөл зохих этгээд даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад тагдсан буюу еер хэргийн учир ял шийтгүүлсэн бол эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж дуусгах, оногдуулсан ялыг эдэлж дуусах буюу хугацаанаас нь өмнө суллах хүртэл шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно.

#### 64 дүгээр зүйл

##### Түр шилжүүлэн өгөх

1. Шилжүүлэн өгөхийг хойшлуулснаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хөөн хэлэлцэх хугацаа дуусахаар буюу гэмт хэргийг байцаан шалгах ажиллагаанд ноцтой бэрхшээл учруулахаар байвал шилжүүлэн өгвөл зохих этгээдийг үндэслэл бүхий хүсэлтээр түр шилжүүлэн өгч болно.

2. Түр шилжүүлэн өгсөн этгээдийг тийнхүү шилжүүлэн өгсөн өдрөөс хойш хоёр сараас хэтрэхгүй хугацааны дотор буцаах ёстой.

#### 65 дугаар зүйл

##### Шилжүүлэн өгөх тухай хэд хэдэн улсын шаардлага

Нэг төрлийн буюу хэд хэдэн төрлийн ял оногдуулж болох хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэн өгөх тухай шаардлагыг хэд хэдэн улсаас ирүүлсэн бол аль шаардлагыг хангах тухай асуудлыг

даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шийдвэрлэнэ.

### 66 дугаар зүйл

Шилжүүлэн өгсөн этгээдийг байцаан шийтгэх хязгаар

1. Шилжүүлэн өгсөн этгээдийг шилжүүлэн өгөхөөс өмнө үйлдсэн бөгөөд шилжүүлэн өгөөгүй хэрэгтэй нь холбогдуулан даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татаж, ял шийтгэж, эсвэл цагдан хорьж буюу гуравдахь улсад шилжүүлэн өгч болохгүй.

2. Зөвшөөрлийг дор дурдсан тохиолдолд шаардахгүй:

а/ шилжүүлэн өгсөн этгээд нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дууссан буюу ял эдэлж дууссан үеэс хойш нэг сарын дотор даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс гарч яваагүй, уг хугацаанд шилжүүлэн өгсөн этгээд өөрөөсөө үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс явж чадаагүй байсан хугацааг оруулан тоолохгүй;

б/ шилжүүлэн өгсөн этгээд даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс яваад дараа нь сайн дураараа эргэж ирсэн.

### 67 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх ажиллагааг гүйцэтгэх

1. Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгөхийг зөвшөөрч байгаа тохиолдолд уг этгээдийг шилжүүлэн өгөх газар, цаг хугацааг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ.

2. Шилжүүлэн өгөх этгээдийг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Тал нь шилжүүлэн өгөхөөр тогтоосон хугацаанаас хойш нэг сарын дотор тогтсон газарт хүлээж авахгүй бол цагдан хоригдсон этгээдийг суллана.



## 68 дугаар зүйл

## Дахин шилжүүлэн өгөх

Шилжүүлэн өгсөн этгээд байцаан шийтгэх ажиллагаанаас буу ял эдлэхээс зайлсхийж даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт буцаж ирвэл даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын шинэ шаардлагын дагуу энэ Гэрээний 58 дугаар зүйлд дурдсан мэдээ, материал гаргуулахгүйгээр уг этгээдийг дахин шилжүүлж өгнө.

## 69 дүгээр зүйл

## Дамжуулан өнгөрүүлэх

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хүсэлтээр гуравдахь улсаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талд шилжүүлэн өгөх этгээдийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх үүрэг хүлээнэ. Хэлэлцэн тохирогч Талууд энэ Гэрээнд шилжүүлэн өгч болохгүй тухай заасан этгээдийг дамжуулан өнгөрүүлэхийг зөвшөөрөх үүрэггүй.

2. Дамжуулан өнгөрүүлэх тухай хүсэлтийг шилжүүлэн өгөх шаардлагын адил журмаар үйлдэж хүргүүлнэ.

## 70 дугаар зүйл

## Шилжүүлэн өгөх болон дамжуулан өнгөрүүлэх зардал

Шилжүүлэн өгөх зардлыг уг зардал нутаг дэвсгэрт нь гарсан Хэлэлцэн тохирогч Тал хариуцна. Дамжуулан өнгөрүүлэхтэй холбогцсон зардлыг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Тал хариуцна.



71 дүгээр зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дунгийн тухай мэдээлэх

Шилжүүлэн өгсөн этгээдийн талаар явуулсан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дунг Хэлэлцэн тохирогч Талууд бие биедээ мэдээлнэ. Хэрэв шилжүүлэн өгсөн этгээд ял шийтгүүлсэн бол таслан шийдвэрлэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсны дараа уг тогтоолын хуулбарыг хургуулна.

72 дугаар зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг

1. Хэлэлцэн тохирогч Талууд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа өөрийн иргэний хувьд Хэлэлцэн тохирогч нэг Талын шаардлагаар хууль тогтоомжийнхоо дагуу эрүүгийн хэрэг үүсгэж, байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүргийг харилцан хүлээнэ.

2. Байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг нь даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор гэмт хэрэг гэх үзэх боловч даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор захиргааны зөрчил гэх үзэх эрх зүйн зөрчилд мөн адил хамаарна.

73 дугаар зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгавар

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгаварт дор дурдсан зүйлийг тусгасан байна:

- а/даалгавар өгсөн байгуулагын нэр;
- б/эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгавар өгөх болсон хэргийн тодорхойлолт;



в/хэргийг үйлдсэн цаг хугацаа, газрын тухай аль болох илүү нарийн заасан мэдээ баримт ;

г/хэргийг гэмт хэрэг гэж үзэх үндэслэл болж байгаа даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хуулийн заалт, түүнчлэн хэргийн талаар байцаан шийтгэх ажиллагаа явуулахад чухал ач холбогдол бүхий хууль тогтоомжийн бусад актын заалт ;

д/сэжигтний овог, нэр, түүний иргэний харьяалал, оршин суугаа буюу оршин байгаа газрын хаяг, хувийн байдлын тухай бусад мэдээ ;

е/хохилогчийн гомдлоор үүсгэдэг эрүүгийн хэргийн хувьд хохилогчийн гомдол болон хохирыг нөхөн төлүүлэх тухай өргөдөл ;

ж/хэрэв гэмт хэргийн улмаас хохирол учирсан бол хохирлын хэмжээний тухай мэдээ.

Даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын мэдэлд байгаа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны материал болон нотлох баримтыг даалгаварт хавсаргана.

2. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгаврыг шилжүүлэн өгөх үед яллагдагч даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт цагдан хоригдож байсан бол түүнийг даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт шилжүүлнэ.

3. Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал эцсийн шийдвэрээ даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ. Эцсийн шийдвэрийн хуулбарыг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хүсэлтээр хүргүүлнэ.

## 74 дүгээр зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа  
явуулсны үр дагавар

Хэлэлцэн тохирогч Талд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгаврыг энэ Гэрээний 72 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлсэн бөгөөд таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон буюу эцсийн өөр шийдвэрийг даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын байгууллага гаргасан бол даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрүүгийн хэрэг үүсгэхгүй бөгөөд нэгэнт үүсгэсэн эрүүгийн хэргийг зогсооно.

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН  
ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ БУСАД АСУУДАЛ

## 75 дугаар зүйл

Гэмт хэрэгтэй холбогдсон эд зүйлийг  
шилжүүлэх

1. Гэмт этгээдийг шилжүүлэн өгөхлөө гэмт хэргийн зэвсэг болсон буюу гэмт хэргийн ул мөртэй эсвэл гэмт хэргийн замаар олсон бүх эд зүйлийг Хэлэлцэн тохирогч Талуудын хуулийн байгууллагууд бие биедээ хүсэлтийн дагуу бололцооны хэрээр уг этгээдийн хамт шилжүүлэн өгнө.

2. Шилжүүлэн өгвөл зохих этгээд нас барсан буюу түүнийг бусад шалтгаанаар шилжүүлэн өгөх бололцоогүй болсон тохиолдолд ч энэ зүйлийн I-д заасан эд зүйлийг шилжүүлэн өгнө.

3. Эдгээр эд зүйлийн хувьд шаардлага тавих эрх бүхий улс буюу гуравдахь этгээдийн эрх халдашгүй хэвээр үлдэнэ. Хэрэв ийм эрх байгаа бол шүүн таслах ажиллагаа дууссаны дараа уг эд зүйлийг эзэмших эрх бүхий этгээдэд нь шилжүүлэн өгөх зорилгоор Хэлэлцэн тохирогч Талд нэн даруй, үнэ төлбөргүйгээр эргүүлэн өгнө.



4. Хэрэв эдгээр эд зүйл нь эрүүгийн өөр хэрэгт хэрэгцээтэй бол даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал тэдгээрийг буцаан өгөхийг түр хойшлуулах буюу богино хугацаанд буцаан өгөх талаар тохиролцож болно.

## 76 дугаар зүйл

Таслан шийдвэрлэх тогтоолын тухай  
болон ял шийтгэгдсэн эсэх тухай  
мэдэгдэх

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний тухайд шүүхийн гаргасан таслан шийдвэрлэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон тухай мэдээг Хэлэлцэн тохирогч нөгөө Талд жил бүр мэдээлж байна.

2. Хэлэлцэн тохирогч Талуудын шүүхээр урьд нь ял шийтгүүлж байсан этгээд даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татагдаж байгаа бол түүний ял шийтгэгдэж байсан тухай мэдээг Хэлэлцэн тохирогч Талууд нэг нэгэндээ хүсэлтээр нь өгнө.

## 77 дугаар зүйл

Харилцах журам

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар шилжүүлэн өгөх хэргийн талаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Прокурорын газар болон Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Прокурорын газар хоорондоо харилцана.

Д Ө Р Ө В Д Ү Г Э Э Р Х Э С Э Г

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

## 78 дугаар зүйл

1. Энэ Гэрээг соёрхон батална.



2. Энэ Гэрээ нь Батламж жуух бичгийг Москва хотноо солилцсон өдрөөс эхлэн гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болох бөгөөд таван жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

3. Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Гэрээний хугацаа дуусахаас зургаан сараас доошгүй хугацааны өмнө Гэрээг цуцлах тухайгаа бичгээр мэдэгдээгүй бол энэ Гэрээ дараачийн таван жил тутамд аяндаа сунгагдана. Гэрээ нь цуцлах тухай мэдэгдсэн өдрөөс хойш нэг жил өнгөрмөгц дуусгавар болно.

79 дүгээр зүйл

Энэ Гэрээ нь Хэлэлцэн тохирогч Талуудын оролцсон олон талын болон хоёр талын хүчин төгөлдөр олон улсын гэрээнээс үүсэн гарах эрх, үүргийг хөндөхгүй.

80 дугаар зүйл

Энэ Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 1958 оны наймдугаар сарын 25-ны өдрийн Иргэний ба эрүүгийн хэрэг, мөнгэр бүл, гэрлэхтэй холбогдсон хэргийн талаар хуулийн туслалцаа харилцан үзүүлэх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хоорондын Гэрээ дуусгавар болно.

Энэ Гэрээ 1988 оны есдүгээр сарын 23-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд хоёр эх адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД  
УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭР-  
ГҮҮЛЭГЧДЭЭС ЭРХ ОЛГОСНООР

ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД  
НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН  
ДЭЭЛ ЗӨВЛӨЛИЙН ТЭРТҮҮ-  
ЛЭГЧДЭЭС ЭРХ ОЛГОСНООР



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС, ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН ХООРОНД 1988 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 23 -НЫ ӨДӨР ГАРЫН ҮСЭГ ЗУРСАН ИРГЭН, ГЭР БҮЛИЙН БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭНИЙ ПРОТОКОЛ

Иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээнд гарын үсэг зурахдаа Хэлэлцэн тохирогч Талуудын бүрэн эрхт төлөөлөгчид дор дурдсан зүйлийг нотолж байна:

Гэрээний 3 дугаар зүйлийн 4-т заасан эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар харилцах ажлыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хувьд Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгаас эдгээр аймгийн шүүх, прокурор гүйцэтгэх болно.

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хувьд уг харилцах ажлыг Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Автономит Буриад Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Автономит Тува Улсаас эдгээр автономит улсын Шүүх яам, Прокурорын газар, харин Алтайн хязгаар, Чит мужаас эдгээр хязгаар, мужийн Ардын Депутатуудын Зөвлөлийн гүйцэтгэх хорооны шүүхийн байгууллагын хэлтэс болон мөн хязгаар, мужийн прокурор гүйцэтгэх болно.

Энэхүү Протокол нь дээр дурдсан Иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн.

1988 оны 9 дүгээр сарын 23 -ны өдөр Улаанбаатар хотноо монгол, орос хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДЭЭС ЭРХ ОЛГОСНООР

ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН ДЭЭД ЗӨВЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭГЧДЭЭС ЭРХ ОЛГОСНООР

*С. Салдуу*

*Б. Улаанбаатар*